

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
	2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
	2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.12. Шилэн дансны мэдээлэл	8
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭНХЦЭЦЭГ
ТАНАА

2020.03.13 № 06/818
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дулаан Шарын гол ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Энхцэцэгт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтын бүрдлийг хангах, нягтлан бодох бүртгэлийг зөв хөтлөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний хэрэгжилт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дулаан Шарын гол ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 25-наас 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Цэгцтөв богд аудит ХХК-ийн Аудитын багийн удирдагч Н.Цэрэнханд, аудитор С.Галсанчоймбол нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/46 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дулаан Шарын гол ТӨХК нь дүрэмдээ “Хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүч, ундны цэвэр усаар тасралтгүй найдвартай хангаж, бохир усыг ариутган татан зайлуулах ба эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажиллахад оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, цэвэр ус олборлох, түгээх, бохир ус татан зайлуулах, суурин газрын ус хангамжийн худаг, ус түгээх цэг, зөөврийн ус хангамж болон орон сууцны барилга байгууламжийн цэвэр, бохир ус, дулаан цахилгааны шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төв, ус хангамж, ариутгал татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

Иймд Эрчим хүчний яамны болон өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ бодлогын баримт бичигт СТОУС-ын болон шинэчлэгдсэн эрхийн актуудын өөрчлөлтүүдийг тусгаагүй байна.

Дулаан Шарын гол ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Дулаан Шарын гол ТӨХК дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дулаан Шарын гол ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 24 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг байгууллага тул сонголоо.

Материаллаг байдлын түвшнийг суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцсон нь эрсдэлийг үр нөлөөтэй гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 3,094.0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 61.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113.4 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.2	1.0	0.8
Авлага	326.6	342.2	15.6
Урьдчилгаа	3.2	36.1	32.9
Бараа материал	152.3	122.4	(29.9)
Үндсэн хөрөнгө	6,741.2	6,608.4	(132.8)
Нийт хөрөнгө	7,223.5	7,110.1	(113.4)
Өр төлбөр	1,462.6	1,673.2	210.6
Эздийн өмч	5,760.9	5,436.9	(324.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,223.5	7,110.1	(113.4)

Авлага дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд цэвэр бохир усны үнэ 10 хувиар нэмэгдсэн, оршин суугчдын ажилгүйдлийн түвшин 20 хувиар өсч төлбөрийн чадвар буурснаас САГ-2020/44/СТА- ТӨҮГ

шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2003 онд үүссэн, он удаан жил болсон байгууллагаас авах 4.7 сая төгрөгийн авлага байна.

Авлага дансны үлдэгдэлд аж ахуйн нэгж байгууллагаас 212.7 сая, оршин суугчдаас 122.6 сая, хувь хүмүүсээс авах 6.9 сая нийт 342.3 сая төгрөгийн авлага байна.

Шарын гол ХК-аас авах 178.0 сая төгрөгийн авлагыг Дархан уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 1116 тоот шийдвэрээр Дулаан шарын гол ТӨХК-д олгохоор шийдвэрлэсэн боловч хариуцагч тал давж заалдах шатанд өргөдөл гаргаж шүүхийн шатандаа байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь үндсэн үйлдвэрлэлийн түүхий эд болох нүүрс тайлант оны эхэнд 26.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг зарцуулж дууссан, мөн олдоц ховор цахилгаан, сантехникийн сэлбэг оны эхэнд нөөц үлдэгдэлтэй байсныг тайлант онд хэрэгцээгээр нь хэсэг цехүүдэд тавьж олгосоноос шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2003-2008 онд худалдаж авсан ашиглалтгүй 5.9 сая төгрөгийн сантехникийн сэлбэг байна. Энэ нь хугацаа удах тусам техникийн дэвшлийн хоцрогдолд орж, зах зээлд борлогдох үнэ цэнээ алдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө акталж данснаас хассан, үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

2019 оны зорилтот түвшинд тусгагдсан их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжүүлсэн 145.1 сая төгрөгийн их засварын ажлыг капиталжуулсан, өөрийн хөрөнгөөр 98.9 сая төгрөгийн (машин тоног төхөөрөмж 82.0 сая, тавилга эд хогшил 7.4 сая, компьютер, бусад хэрэгсэл 9.4 сая) хөрөнгийг худалдаж авсан, ТӨБЗГ-ын 2019 оны 46 тоот тогтоолоор Барилгын хөгжлийн төвөөс 44.0 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 288.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 196 тоот тогтоолоор 79.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө өссөн буурсан нь элэгдэлийн байгуулснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь орлого буурсны улмаас татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өглөг нэмэгдсэн, орлогын дутагдлыг нөхөх, өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор 150.0 сая төгрөгийн шугамын зээлийг арилжааны банкнаас авсан зэргээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2018 онд автомашин худалдан авах зорилгоор ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн урт хугацаат зээл авсан 42.5 сая, үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг хойшлогдсон өглөгөөр бүртгэснээс үүссэн 36.5 сая нийт 79.0 сая төгрөгийн өр бүртгэлтэй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 5,436.9 сая төгрөг болж 323.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Эрчим Хүчний Сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 08 тоот тушаалаар Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны зорилтот түвшнийг 2,531.5 сая төгрөгийн орлоготой, 3,618.1 сая төгрөгийн зардалтай, 586.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталсан, мөн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 275 дугаар тушаалаар зорилтот

түвшнийг 2,693.1 сая төгрөгийн орлоготой 3,726.2 сая төгрөгийн зардалтай, 533.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тодотгож баталсан байна.

Тайлант онд 2,693.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2,639.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 53.7 сая төгрөгөөр орлого тасарсан нь 5 дугаар сар, 9 дүгээр саруудад хоёр төсвийн байгууллага халаалт аваагүй, Шарын гол ХК төсөвлөснөөс дутуу дулаан хэрэглэсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,418.8 сая төгрөг болж төлөвлөгөөнөөс 307.4 сая төгрөгийг дутуу зарцуулсан нь орон тоо дутуу ажилласан, шагналт цалин төлөвлөснөөс бага олгосноос 121.9 сая, цахилгааны тоног төхөөрөмжийн шинэчлэлтээс цахилгааны зардал 17.6 сая, урсгал засвар болон сэлбэг хангамжийн зардлаас 20.2 сая, шатахууны зардал 16.3 сая, түлшний зардал 50.7 сая, туслах аж ахуйн 6.3 сая, бусад 74.4 сая төгрөгийг тус тус хэмнэж, эргэлтийн хөрөнгийн шугамын зээл авснаар 11.6 сая төгрөгийн хүүгийн зардал гарсан байна.

Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 онд тодотгож батлагдсан алдагдал 208.3 сая төгрөгөөр буурсан нь зардал төлөвлөсөн хэмжээнээс буурснаас шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 51.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 51.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

- Зорилтот түвшний орлогын төлөвлөгөө тасарсан, авлага, өр төлбөр нэмэгдсэн нь Эрчим хүчний сайдын 2019 оны 275 дугаар тушаалаар батлагдсан зорилтот түвшинг хангах заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

- Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл аваагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр арилжааны банкнаас богино хугацаат зээл авч өглөг үүсгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16-д "Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана" гэсэн заалттай нийцээгүй санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 51.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дулаан Шарын гол ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянахад Эрчим хүчний яамнаас хөрөнгө оруулалт, болон бусад гэсэн чиглэлээр цахим данс хөтлөхөөр чиглэл өгсөний дагуу мэдээлж, эрчим хүчний яам хангалттай гэсэн

үнэлгээ өгч байгаа гэсэн тайлбар хийж Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор заагдсан мэдээллүүдийг бүрэн мэдээлээгүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилт 93.4 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 51.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 61.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Дулаан Шарын гол ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дулаан Шарын гол ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Анхан шатны бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Шинэчлэгдэн батлагдсан батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг бүрэн хөтлөөгүй гарын үсгийн бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1-д “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, мөн хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийн хангаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль, журам зөрчигдөх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

3.1.3 Зөвлөмж:

Худалдан авсан бараа материал, хөрөнгийн Е-баримтыг бүрэн авч, нягтлан бодогч шалгаж баталгаажуулан бүрдлийг хангаж ажиллах

3.1.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Авлагын 28.0 сая төгрөг, өр төлбөрийн 1.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг

зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийн хангаагүй байна

3.2.2 Эрсдэл:

Найдваргүй авлага үүсэх, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.2.3 Зөвлөмж:

Авлага өглөгийн үлдэгдлийг харилцагчидтай тооцог нийлж актаар баталгаажуулах, хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.2.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллана.

3.3. Балансын дансын данстай холбоотой асуудал.

3.3.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 96 нэр төрлийн 14.0 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө ашиглагдаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т " илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1-д "Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.3.3 Зөвлөмж

Үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглах бол ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүсэлт гаргаж дахин үнэлэх асуудлыг шийдвэрлүүлэх:

3.3.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31	
1	ХӨРӨНГӨ			
1.1	Эргэлтийн хөрөнгө			
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	249,278.42	1,010,539.51	
1.1.02	Дансны авлага	314,413,591.72	335,329,204.51	
1.1.04	Бусад авлага	12,137,668.50	6,925,797.89	
1.1.06	Бараа материал	152,315,797.57	122,427,390.52	
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,167,947.39	36,074,337.73	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	482,284,283.60	501,767,270.16	
1.2	Эргэлтийн бус хөрөнгө			
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,632,781,242.59	6,506,424,937.61	
1.2.02	Биет бус хөрөнгө	105,208,658.97	98,732,522.65	
1.2.03	Биологийн хөрөнгө	3,230,000.00	3,230,000.00	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,741,219,901.56	6,608,387,460.26	
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,223,504,185.16	7,110,154,730.42	
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
2.1	Өр төлбөр			
2.1.1	Богино хугацаат өр төлбөр			
2.1.1.01	Дансны өглөг	871,638,813.91	869,019,175.41	
2.1.1.02	Цалингийн өглөг	67,892,793.69	0.00	
2.1.1.03	Татварын өр	284,858,452.39	411,655,665.46	
2.1.1.04	НДШ - ийн өглөг	118,531,494.79	175,123,312.60	
2.1.1.05	Богино хугацаат зээл	0.00	138,384,547.90	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,342,921,554.78	1,594,182,701.37	
2.1.2	Урт хугацаат өр төлбөр			
2.1.2.01	Урт хугацаат зээл	119,700,000.00	42,536,403.31	
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	36,519,114.70	
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	119,700,000.00	79,055,518.01	
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,462,621,554.78	1,673,238,219.38	
2.3	Эздийн өмч			
2.3.01	Өмч: - төрийн	6,525,993,994.35	6,525,993,994.35	
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	849,125,687.82	850,017,239.82	
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	89,304,000.00	89,304,000.00	
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,703,541,051.79	-2,028,398,723.13	
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-324,857,671.34	
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,703,541,051.79	-1,703,541,051.79	
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,760,882,630.38	5,436,916,511.04	
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,223,504,185.16	7,110,154,730.42	

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,904,550,506.05	2,937,349,339.53
02	Борлуулалтын өртөг	2,967,963,443.39	3,164,400,729.10
03	Нийт ашиг(алдагдал)	-63,412,937.34	-227,051,389.57
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	1,320,427.86	686,562.12
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	217,991,199.51	155,926,357.86
08.1	Орлогын дүн	219,311,627.37	156,612,919.98
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	129,212,065.29	134,326,444.03
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	71,569,847.25	120,024,101.51
12.1	Зардлын дүн	200,781,912.54	254,350,545.54
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-44,883,222.51	-324,789,015.13
19	Орлогын татварын зардал	132,042.78	68,656.21
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-45,015,265.29	-324,857,671.34
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-45,015,265.29	-324,857,671.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,216,197,734.24	2,336,911,569.95
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,708,896,238.24	1,566,023,243.21
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	500,000,000.00	500,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,301,496.00	270,888,326.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,106,893,452.98	2,339,526,472.19
1.2.1	Ажиллагчдад төлсөн	936,875,022.81	1,035,934,500.42
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	332,529,584.00	243,012,685.28
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	434,286,394.11	523,399,074.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	81,488,776.40	45,471,032.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	57,562,369.97	75,000,590.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	24,527,859.03
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	225,220,455.92	119,712,345.75
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,442,058.00	3,325,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	36,488,791.77	269,143,385.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	109,304,281.26	-2,614,902.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,320,427.86	686,562.12
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,320,427.86	686,562.12
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	248,850,000.00	58,531,350.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	248,850,000.00	58,531,350.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-247,529,572.14	-57,844,787.88
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	119,700,000.00	151,260,345.50
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	119,700,000.00	151,260,345.50
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	90,039,394.29
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	90,039,394.29
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	119,700,000.00	61,220,951.21
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-18,525,290.88	761,261.09
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,774,569.30	249,278.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	249,278.42	1,010,539.51

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг/ алдагдал/	Нийт дүн
2017 оын 12 сарын 31-нээрх үлдэгдэл	2,272,713,862.35	12,160,756.82	1,287,852,253.36	-2,958,538,796.68	614,188,075.85
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	1,300,013,010.18	1,300,013,010.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-45,015,265.29	-45,015,265.29
Өмчид гарсан өөрчлөлт	4,253,280,132.00	0.00	-1,198,548,253.36	0.00	3,054,731,878.64
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	836,964,931.00	0.00	0.00	836,964,931.00
2018 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,525,993,994.35	849,125,687.82	89,304,000.00	-1,703,541,051.79	5,760,882,630.38
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-324,857,671.34	-324,857,671.34
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	891,552.00	0.00	0.00	891,552.00
2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,525,993,994.35	850,017,239.82	89,304,000.00	-2,028,398,723.13	5,436,916,511.04

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.14	Аудитын нэр: Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны жилийн зисийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/44/-СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дулаан шарын гол ТӨХК	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг бүрэн хөтлөөгүй гарын үсгийн бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан	8.2	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
2	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 96 нэр төрлийн 14.0 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө ашиглагдаж байна .	14.0	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
3	Авлагын 28.0 сая төгрөг, өр төлбөрийн 1.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж батал-гаажуулаагүй байна.	29.6	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
4	Зорилтот түвшний орлогын төлөвлөгөө тасарсан, авлага, өр төлбөр нэмэгдсэн		Албан шаардлага өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
5	Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл аваагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр арилжааны банкнаас богино хугацаат зээл авч өглөг үүсгэсэн		Албан шаардлага өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
	ДҮН	51.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 23

№ 02/154

СДҮГ- 2020/44/СТЭ-ТӨМГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө тасарсан, авлага, өр төлбөр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;
- Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр богино хугацаат зээл авч, өглөг үүсгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.16-д "Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана" гэсэн заалтуудтай нийцэхгүй

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх", "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан зорилтот түвшний үзүүлэлтийг нэр төрөл бүрээр ханган биелүүлэх
2. Арилжааны банкнаас зээл авахад Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч байх.
3. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулаан шарын гол ТӨХК-ийн захирал Б.Энхцэцэг, Ерөнхий нягтлан бодогч Ж.Даш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Л.МӨНХЦАЦРАЛ

"ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Н.ЦЭРЭНХАНД

ЗӨВШӨӨРСӨН:

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.ЭНХЦЭЦЭГ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Ж.ДАШ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 03

№ 02/154

Улаанбаатар хот

СЯГ- 00 00/44/ СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Дулаан шарын гол ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө тасарсан, авлага, өр төлбөр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;
- Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр богино хугацаат зээл авч, өглөг үүсгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.16-д "Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана" гэсэн заалтуудтай нийцэхгүй

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх", "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан зорилтот түвшний үзүүлэлтийг нэр төрөл бүрээр ханган биелүүлэх
2. Арилжааны банкнаас зээл авахад Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч байх.
3. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулаан шарын гол ТӨХК-ийн захирал Б.Энхцэцэг, Ерөнхий нягтлан бодогч Ж.Даш нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Л.МӨНХЦАЦРАЛ

"ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Н.ЦЭРЭНХАНД

ЗӨВШӨӨРСӨН:

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.ЭНХЦЭЦЭГ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Ж.ДАШ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь залах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харуулагч албан тушаалтанд харуулага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

